



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 7 сарын 20 өдөр

Дугаар 150

Улаанбаатар хот

Нийтэд санал болгохыг зөвшөөрсөн
үнэт цаасны бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 26 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 77 дугаар тогтоолын 4.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол эсгий, эсгий гутал” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан нийт 114,378 /нэг зуун арван дөрвөн мянга гурван зуун далан найм/ ширхэг энгийн хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “ҮЦГХТ” ХХК /Ш.Лхагва/-д тус тус үүрэг болгосугай.

2. Компанийг татан буулгах шийдвэр гарсантай холбогдуулан компанийн үлдэгдэл эд хөрөнгийг хувьцаа эзэмшигчид хуваарилах, нэгж хувьцаанд ногдох хөрөнгийг 5,511 /таван мянга таван зуун арван нэг/ төгрөгөөр тооцон компанийн хувьцаа эзэмшигчид хуваарилах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийн тайланг ажлын 15 хоногт багтаан Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Монгол эсгий, эсгий гутал” ХК /З.Уранчимэг/-д үүрэг болгосугай.

3. Компани татан буугдаж байгаатай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, жижиг хувьцаа эзэмшигчдэд ногдох хөрөнгийн хуваарилалтад хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалт, зохицуулалтын газар /Б.Ариунаа/-г үүрэг болгосугай.

4. Тогтоол батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдээлэл хүргэх, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН